

**“СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2021 оны 3 сарын 15 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай**

“Стандарт агрикалчер групп” ХК –ийн 2021 оны 3-р сарын 15 –ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын нэгдүгээр тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** “Стандарт Агрикалчер групп” ХК –ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 4-р сарын 26–ний өдөр 10:00 цагт мэдээллийн технологи, программ хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж хурлыг хуралдуулсугай. Хурлыг ТУЗ –ийн дарга Г.Хатанболд даргалсугай.

**Хоёр.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4-р сарын 2-ний өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл” –ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2021 оны 3-р сарын 17 –ний өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” –ын дагуу 2021 оны 3-р сарын 18–ний өдөр болон 2021 оны 4-р сарын 2–ний өдрүүдэд олон нийтэд зарласугай.

**Гурав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2021 оны 3-р сарын 22–ний өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

**Дөрөв.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

**Тав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтуудын жагсаалт, уг бичиг баримтуудтай танилцаж болох газар, хугацааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

**Зургаа.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

**Долоо.** Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2021 оны 4 сарын 23 –ний өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

**Найм.** Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг тавдугаар хавсралтаар баталсугай.

**“СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2014 оны 3 сарын 15 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг даалгасугуй.

Зохион байгуулах комиссын дарга: Л.Золбаяр

Гишүүн: Л.Гантуяа

Арав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилж, даалгах ажлыг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Тооллогын комиссын дарга: Л.Оюунжаргал

Гишүүд: Б.Дэжидмаа, С.Сувд-Эрдэнэ

ТУЗ –ийн ДАРГА:



Г.ХАТАНБОЛД/